



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 14 өдөр

Дугаар А/198

Номгон

ГТүүх соёлын дурсгалт газар, соёлын биет
болон биет бус өвийг өвлөн уламжлагчдыг
илрүүлэх, сурталчлах ажлыг зохион
байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.2, 16.1.8, Соёлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөг батлах тухай 12/54 дугаар тогтоолын хавсралтын 1.6.1 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Түүх соёлын дурсгалт газар, соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдыг илрүүлэх, сурталчлах, дэмжих ажлыг 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдрөөс 12 дугаар сарын 01-ний хооронд зохион байгуулсугай.

2.Тус ажлыг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Б.Наранбаяр), Түүх угсаатны зүй байгалийн түүхийн музей (Р.Пүрэвсүрэн) нарт тус тус үүрэг болгосугай.

3.Дээрх үйл ажиллагаанд зарцуулагдах 14.000.000 (Арван дөрвөн сая) төгрөгийг аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг орлогч (Б.Батсуурь)-д даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

642310500